



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2023/14/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2023 оны 03 дугаар сарын 24

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Агуулга	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	14
3.5.1 Мөнгөн хөрөнгө	14
3.5.2 Авлага	14
3.5.6 Бараа материал	15
3.5.7 Үндсэн хөрөнгө	16
3.5.8 Өр төлбөр	17
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо	17
3.5.10 Орлогын данс	17
3.5.11 Зардлын данс	18
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	21
3.8 Аудитын гол асуудал	21
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	23
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24
4.6.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	24
4.7.1 Завсрын аудитын талаар	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	25
5.1 Зөвлөмж	25
5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.03.24 № 2/124

танай _____-ны № _____-т

БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
О.МӨНХБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Баянлиг сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянлиг сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тайлант онд төсвийн шинэчлэлтэй холбоотойгоор ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн санхүүгийн тайлан Боловсролын ерөнхий газарт, эрүүл мэндийн төвийн тайлан Эрүүл мэндийн яаманд, соёлын төвийн тайлан Соёлын яаманд нэгтгэгдэж, тайланд хөрөнгийг шилжүүлэн бүртгэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Төсвийн шинэчлэлтэй холбоотой нийт 11,222,110.5 мянган төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр балансаас баланст шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын засаг даргын 2022 үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж,

005020479

дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангалттай гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Баянлиг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Сумын Засаг дарга санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a rectangular official stamp. The stamp contains a central emblem and some illegible text in Mongolian. The signature is a stylized, cursive script.

Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,100,726.71	737,046.81
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	435,241.73	548,469.77
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0	0
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	435,241.73	548,469.77
31210	Төгрөг	435,241.73	548,469.77
31211	Төрийн сангийн харилцах	435,241.73	548,469.77
33	АВЛАГА	285,214.81	49,495.35
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	572.13	0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	185,700.20	0
33500	Бусад авлага	29,503.00	4,240.00
33510	Байгууллагаас авах авлага	18,940.00	0
33520	Хувь хүмүүсээс авах авлага	10,563.00	4,240.00
33600	Зээлийн авлага	69,439.48	45,255.35
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	69,439.48	45,255.35
33612	Хувь хүмүүст олгосон зээл	69,439.48	45,255.35
35	БАРАА МАТЕРИАЛ	380,270.17	139,081.70
35100	Түүхий эд материал	78,724.30	3,294.39
35110	Тусгай зориулалттай материал	67,362.43	3,294.39
35130	Эм боох материал	11,361.87	0
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	65,936.30	48,975.80
35400	Хангамжийн материал	230,599.57	82,851.51
35410	Бичиг хэргийн материал	12,145.88	4,805.52
35420	Аж ахуйн материал	190,289.87	37,307.02
35430	Сэлбэг хэрэгсэл	1,800.00	0
35440	Түлш, шатах тослох материал	2,208.62	0
35460	Хүнсний материал	868.43	0
35470	Бусад хангамжийн материал	23,286.77	40,738.97
35600	Мал амьтад	5,010.00	3,960.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,824,772.10	4,412,688.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,824,772.10	4,412,688.97
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	12,650,297.67	4,313,938.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	14,036,881.49	5,336,115.38
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,323,125.06	-1,526,049.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	339,411.80	247,927.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	-198,559.36	-156,996.52
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	955,240.15	348,448.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-605,773.82	-202,086.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	466,358.44	157,634.63
39208	Хуримтлагдсан элэгдэл	-272,544.40	-98,300.93
39209	Зам, гүүрийн байгууламж	32,752.76	32,752.76
39210	Хуримтлагдсан элэгдэл	-3,579.07	-4,876.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	266,258.82	265,758.82
39215	Хуримтлагдсан элэгдэл	-86,489.77	-86,389.77
39217	Ном	43,465.70	0
39300	Биет бус хөрөнгө	174,474.43	98,750.43
39301	Программ хангамж	3,634.06	2,704.06

**Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,087.60	-2,417.60
39303	Бусад биет бус хөрөнгө	178,946.75	103,482.75
39304	Хуримтлагдсан элэгдэл	-5,018.78	-5,018.78
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,925,498.81	5,149,735.78
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,378.87	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,378.87	0
41300	Өглөг	12,378.87	0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	460.67	0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	11,022.81	0
41360	Бусад өглөг	895.40	0
41361	Байгууллагад төлөх өглөг	872.60	0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	22.80	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,913,119.94	5,149,735.78
51	Засгийн газрын хувь оролцоо	13,913,119.94	5,149,735.78
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,688,524.85	513,185.77
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,688,524.85	513,185.77
51200	Хуримтлагдсан үр дүн	11,147,402.87	4,558,745.77
51210	Өмнөх үеийн үр дүн	11,147,402.87	13,129,296.47
51220	Тайлант үеийн үр дүн		-8,570,550.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,077,192.22	77,804.23
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13,925,498.81	5,149,735.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,101,121.34	3,012,882.99
11	ТАТВАРЫН ОРЛОГО	123,833.40	431,573.49
110	Орлогын албан татвар	107,288.90	311,068.04
1100	Хувь хүний орлогын албан татвар	107,288.90	311,068.04
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр зрх	0	228,396.20
110002	Үйл ажиллагааны орлого	34,564.62	31,806.26
110003	Хөрөнгийн орлого	69,434.14	50,065.58
110004	Хөрөнгө борлуулсны орлого	3,290.13	800.00
113	Хөрөнгийн албан татвар	1,387.00	101,408.34
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0	2,381.59
113002	Бууны албан татвар	1,387.00	1,740.00
113004	Малд ногдуулах албан татвар	0	97,286.75
118	Бусад татвар, төлбөр, хураамж	15,157.50	19,097.10
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	13,913.35	15,389.85
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2,328.95	2,963.76
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500.00	250.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	11,084.40	12,176.09
1181	Газрын төлбөр	1,244.16	3,218.91
118101	Газрын төлбөр	1,244.16	3,218.91
1183	Бусад татвар	0	488.34
118301	Бусад татвар	0	488.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	372,916.36	1,468,899.29
120	Нийтлэг татварын бус орлого	372,916.36	1,468,899.29
120003	Торгуулийн орлого	6,120.00	2,490.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	60,569.00	8,567.89

**Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,720.74	4,230.39
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,848.26	4,337.50
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	206,778.11	1,435,841.39
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	99,449.25	22,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,604,371.58	1,112,410.22
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,131,160.98	38,039.90
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,475.48	38,039.90
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,098,685.50	0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	531,207.56	14,217.32
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	163,579.72	9,956.28
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	38,742.84	4,261.04
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	328,885.00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,911,828.08	1,060,153.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	936,951.28	0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	786,023.80	668,984.90
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	188,853.00	391,168.10
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	30,174.96	0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,174.96	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,144,586.12	1,750,075.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,144,586.12	1,750,075.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,993,877.25	1,174,534.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,894,842.90	313,873.23
210101	Үндсэн цалин	1,735,640.57	258,408.47
210102	Нэмэгдэл	115,966.99	32,365.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,263.89	1,868.00
210104	Урамшуулал	36,971.47	20,426.43
210105	Гэрээт ажлын хөлс	0	804.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	246,264.64	39,830.01
210201	Тэтгэврийн даатгал	213,495.31	27,440.87
210202	Тэтгэмжийн даатгал	8,529.49	3,228.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,749.31	2,542.35
210204	Ажилгүйдлийн даатгал	1,589.99	584.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,900.54	6,034.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	392,573.53	27,176.40
210301	Гэрэл, цахилгаан	16,943.71	5,218.20
210302	Түлш, халаалт	375,629.82	21,958.20
2104	Хангамж, бараа материалын зардал	249,464.76	140,549.67
210401	Бичиг хэрэг	18,067.76	11,465.81
210402	Тээвэр, шатахуун	61,682.75	47,654.31
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,061.10	0
210404	Ном, хэвлэл	330.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,851.60	15,266.75
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	117,587.86	226.50
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	139.00	0
210408	Бараа материал акталсны зардал	7,944.70	0
210409	Бараа материал шилжүүлсний зардал	23,800.00	65,936.30
2105	Нормативт зардал	157,409.90	10,166.00

**Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	104,647.83	0
210502	Хоол, хүнс	48,961.07	10,166.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,801.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,977.50	2,568.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	210.00	0
210604	Урсгал засвар	26,767.50	2,568.00
2107	Томилолт, зочны зардал	5,498.90	4,814.00
210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	5,498.90	4,814.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	155,394.91	9,549.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	149,900.91	5,985.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,450.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,044.00	3,564.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	865,450.20	626,007.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	166,967.00	356,570.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,748.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	693,735.20	269,436.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,150,708.88	575,540.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,481.79	24,445.01
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,082.60	23,245.01
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	72,211.79	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,187.40	1,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	969,954.14	551,095.72
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	936,951.28	548,681.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,475.48	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	527.39	2,414.22
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	84,272.94	0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	84,272.94	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-43,464.78	1,262,807.75
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	29,739.84	9,833,358.44
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	29,739.84	98.54
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0	9,585,920.79
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0	247,339.11
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-73,204.62	-8,570,550.69

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,676,546.50	1,583,053.73
11	ТАТВАРЫН ОРЛОГО	123,833.40	431,573.49
110	Орлогын албан татвар	107,288.90	311,068.04
1100	Хувь хүний орлогын албан татвар	107,288.90	311,068.04
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	0	228,396.20
110002	Үйл ажиллагааны орлого	34,564.62	31,806.26

**Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

110003	Хөрөнгийн орлого	69,434.14	50,065.58
110004	Хөрөнгө борлуулсны орлого	3,290.13	800.00
113	Хөрөнгийн албан татвар	1,387.00	101,408.34
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0	2,381.59
113002	Бууны албан татвар	1,387.00	1,740.00
113004	Малд ногдуулах албан татвар	0	97,286.75
118	Бусад татвар, төлбөр, хураамж	15,157.50	19,097.10
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	13,913.35	15,389.85
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2,328.95	2,963.76
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500.00	250.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	11,084.40	12,176.09
1181	Газрын төлбөр	1,244.16	3,218.91
118101	Газрын төлбөр	1,244.16	3,218.91
1183	Бусад татвар	0	488.34
118301	Бусад татвар	0	488.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	134,041.71	39,070.02
120	Нийтлэг татварын бус орлого	134,041.71	39,070.02
120003	Торгуулийн орлого	6,120.00	2,490.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	127,921.71	36,580.02
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,643.45	32,380.02
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	61,278.26	4,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,418,671.38	1,112,410.22
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,131,160.98	38,039.90
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,475.48	38,039.90
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,098,685.50	0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	345,507.36	14,217.32
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	168,472.52	9,956.28
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	38,742.84	4,261.04
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	138,292.00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,911,828.08	1,060,153.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	936,951.28	0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	786,023.80	668,984.90
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	188,853.00	391,168.10
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	30,174.96	0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,174.96	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,286,950.73	1,091,158.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,286,950.73	1,091,158.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,135,514.25	1,026,259.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,893,616.36	373,554.99
210101	Үндсэн цалин	1,421,863.35	241,279.57
210102	Нэмэгдэл	331,080.87	38,466.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,263.86	0
210104	Урамшуулал	127,436.13	31,659.71
210105	Гэрээт ажлын хөлс	6,972.15	62,148.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	246,562.06	47,312.18
210201	Тэтгэврийн даатгал	178,867.79	33,203.01
210202	Тэтгэмжийн даатгал	17,207.37	3,641.18

**Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210203	ҮОМШӨ-ний даатгал	13,677.02	2,859.09
210204	Ажилгүйдлийн даатгал	3,372.41	677.22
210205	Эрүүл мэндийн даатгал	33,437.47	6,931.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	388,406.47	466,529.76
210301	Гэрэл, цахилгаан	15,972.99	24,409.63
210302	Түлш, халаалт	372,433.48	442,120.13
2104	Хангамж, бараа материалын зардал	107,058.12	63,413.53
210401	Бичиг хэрэг	13,638.70	7,881.20
210402	Тээвэр, шатахуун	58,039.82	38,410.83
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,095.10	0
210404	Ном, хэвлэл	2,930.00	600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,267.70	15,685.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,086.80	836.50
2105	Нормативт зардал	85,370.77	12,118.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,948.80	0
210502	Хоол, хүнс	46,604.97	11,718.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,817.00	400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,299.80	9,595.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,459.80	0
210602	Тавилга	0	900.00
210604	Урсгал засвар	48,840.00	8,695.50
2107	Томилолт, зочны зардал	5,428.90	4,814.00
210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	5,428.90	4,814.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	280,424.50	13,023.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	275,167.40	9,059.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,322.10	400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,935.00	3,564.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,347.28	35,898.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,514.58	35,898.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,832.70	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,151,436.48	64,899.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,209.39	24,445.01
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,335.10	23,245.01
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	72,211.79	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,662.50	1,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	969,954.14	40,454.12
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	936,951.28	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,475.48	38,039.90
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	527.39	2,414.22
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	84,272.94	0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	84,272.94	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	389,595.77	491,894.89
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	213,300.54	378,666.84

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	213,300.54	378,666.84
2200	Дотоод эх үүсвэрээр	213,300.54	378,666.84
220001	Барилга байгууламж	145,207.94	371,135.34
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	68,092.60	7,531.50
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-213,300.54	-378,666.84
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	176,295.23	113,228.04
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	258,946.50	435,241.73
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	435,241.73	548,469.77

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,688,524.85	1,085,257.57	11,212,542.14	13,986,324.55
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	8,065.35	8,065.35
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,688,524.85	1,085,257.57	11,220,607.49	13,994,389.90
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-8,065.35	0	-8,065.35
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-73,204.62	-73,204.62
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,688,524.85	1,077,192.22	11,147,402.87	13,913,119.94
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,688,524.85	1,077,192.22	11,147,402.87	13,913,119.94
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,175,339.07	-999,387.99	1,981,893.60	-192,833.46
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	513,185.77	77,804.23	13,129,296.47	13,720,286.47
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-8,570,550.69	-8,570,550.69
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	513,185.77	77,804.23	4,558,745.77	5,149,735.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,942,908.80	1,417,568.47	525,340.33	72.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,307,139.80	1,046,433.12	260,706.68	80.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,282,691.70	1,021,988.11	260,703.59	79.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,684.70	373,554.99	9,129.71	97.61
210101	Үндсэн цалин	243,054.60	241,279.57	1,775.03	99.27
210102	Нэмэгдэл	38,778.70	38,466.76	311.94	99.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0	0.00	0.00
210104	Урамшуулал	33,990.90	31,659.71	2,331.19	93.14

**Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210105	Гэрээт ажлын хөлс	66,860.50	62,148.96	4,711.54	92.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,688.90	47,312.18	1,376.72	97.17
210201	Тэтгэврийн даатгал	33,453.30	33,203.01	250.29	99.25
210202	Тэтгэмжийн даатгал	3,858.30	3,641.18	217.12	94.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,069.90	2,859.09	210.81	93.13
210204	Ажилгүйдлийн даатгал	738.10	677.22	60.88	91.75
210205	Эрүүл мэндийн даатгал	7,569.30	6,931.68	637.62	91.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	498,689.70	466,529.76	32,159.94	93.55
210301	Гэрэл, цахилгаан	28,507.50	24,409.63	4,097.87	85.63
210302	Түлш, халаалт	465,902.20	442,120.13	23,782.07	94.90
210303	Цэвэр, бохир ус	4,280.00	0	4,280.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	68,187.20	63,413.53	4,773.67	93.00
210401	Бичиг хэрэг	8,096.20	7,881.20	215.00	97.34
210402	Тээвэр, шатахуун	42,772.70	38,410.83	4,361.87	89.80
210404	Ном, хэвлэл	733.30	600.00	133.30	81.82
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,685.00	15,685.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	900.00	836.50	63.50	92.94
2105	Нормативт зардал	12,504.70	12,118.00	386.70	96.91
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	0	0.00	0.00
210502	Хоол, хүнс	12,104.70	11,718.00	386.70	96.81
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400.00	400.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,796.00	12,127.00	1,669.00	87.90
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,800.00	1,800.00	0.00	100.00
210602	Тавилга	1,646.00	1,631.50	14.50	99.12
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	0	0.00	0.00
210604	Урсгал засвар	10,350.00	8,695.50	1,654.50	84.01
2107	Томилолт, зочны зардал	4,821.80	4,814.00	7.80	99.84
210702	Дотоод албан томилолт	4,821.80	4,814.00	7.80	99.84
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,393.00	6,220.50	172.50	97.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,429.00	2,256.50	172.50	92.90
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400.00	400.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564.00	3,564.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	246,925.70	35,898.15	211,027.55	14.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	246,925.70	35,898.15	211,027.55	14.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,448.10	24,445.01	3.09	99.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,448.10	24,445.01	3.09	99.99
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,248.10	23,245.01	3.09	99.99
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200.00	1,200.00	0.00	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	635,769.00	371,135.34	264,633.66	58.38
220001	Барилга байгууламж	635,769.00	371,135.34	264,633.66	58.38
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,942,908.80	1,534,627.35	408,281.45	78.99
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	393,331.40	0	393,331.40	0.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0	0.00	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,160,354.40	1,498,047.32	-337,692.92	129.10

320001	Орон нутгийн төсвөөс	1,160,354.40	1,106,879.22	53,475.18	95.39
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	393,331.40	391,168.10	2,163.30	99.45
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	389,223.00	36,580.02	352,642.98	9.40
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,341.00	32,380.02	-10,039.02	144.94
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,200.00	4,200.00	0.00	100.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	362,682.00	0	362,682.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	362,682.13	-362,682.13	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	479,741.01	-479,741.01	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	56	54	2.00	96.43
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	2	2	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	27	26	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	9	9	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0.00	100.00
620004	Гэрээт ажилтан	2	1	0.00	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6	0.00	100.00
650010	Гэрээт ажилтан	2	1	0.00	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,217.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,217.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,803.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,803.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,803.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,414.22
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,414.22
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,414.22
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,217.32
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,217.32
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,956.28
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,261.04

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу

Баянлиг сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, дарга тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх албан бичгийг 2023.01.11-ний өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлж, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн байна.

Сумын Засаг даргаар О.Мөнхбат, санхүүгийн албаны даргаар Ш.Хоролсүрэн (2022.01.01-2022.01.24, 2022.02.28-2022.12.31), Ж.Оюунтунгалаг (2022.01.25-2022.02.27) нар ажилласан байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хүний хөгжлийг дээдэлсэн төрийн цогц үйлчилгээтэй, уламжлалт мал аж ахуй, газар тариаланг эрчимжүүлсэн, байгальд ээлтэй шинэ технологи бүхий үйлдвэр, дэд бүтэц, аялал жуулчлал хөгжсөн "Манлайлагч сум болох” гэж тодорхойлжээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг чандлан баримталж, иргэдийн ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ хуулийн хүрээнд төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэж, төрд чин үнэнчээр зүтгэж ажиллах зорилт тавьж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2022 оны 1, 2, 3 дугаар улирлыг хамруулан шалгалт хийсэн, харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Төрийн аудитын байгууллагаас Баянлиг сумын Засаг даргын харьяаны байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр		
	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудитад хамрагдаагүй
Төсвийн шууд захирагч	0	4	-
Дүн	0	4	-

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2018 онд аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,175,159.4 мянган төгрөгийн 1.5 хувь буюу 62,627.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 43,839.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 435,241.7 мянган, эцсийн үлдэгдэл 548,469.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 113,228.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дунд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	0	0	0	0
Төрийн санд байгаа бэлэн мөнгө	435,241.7	548,469.8	(113,228.0)	100%
Орон нутгийн ерөнхий орлого	72,559.6	68,728.8	3,830.8	12.5%
Орон нутгийн хөгжлийн сан	176,554.1	269,164.8	(92,610.8)	49.1%
Сум хөгжүүлэх сан	186,128.1	210,576.2	(24,448.1)	38.4%
Замд яваа мөнгөн хөрөнгө	0	0	0	
Хадгаламж	0	0	0	
Дүн	435,241.7	548,469.8	(113,228.0)	100%

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцэс дэх нийт мөнгөн хөрөнгийн 12.5 хувийг орон нутгийн ерөнхий орлого, 38.4 хувийг сум хөгжүүлэх сан, 49.1 хувийг ОНХС-ийн харилцах дансны үлдэгдэл эзэлж байна.

Орон нутгийн ерөнхий орлогын дансанд оны эцэст 68,728.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээс 53,475.2 мянган төгрөг нь оны эцэс төсөвт байгууллагуудаас төвлөрүүлсэн орлого, 15,253.6 мянган төгрөг нь төлөвлөгөөнөөс давсан татварын орлогын үлдэгдэл байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 285,214.8 мянга, эцсийн үлдэгдэл 49,495.3 мянган

төгрөг болж, өмнөх оноос 235,719.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	572.1	0	572.1
Байгууллагаас авах авлага	18,940.0	0	18,940.0
Хувь хүмүүсээс авах авлага	10,563.0	4,240.0	6,323.0
Татаас санхүүжилтийн авлага	185,700.2	0	185,700.2
Зээлийн авлага	69,439.5	45,255.3	24,184.2
Дүн	285,214.8	49,495.3	235,719.5

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцсийн нийт авлагын 91.4 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 8.6 хувийг хувь хүмүүсээс авах авлага эзэлж байна.

Хүснэгт 3. Байгууллагын авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:				
				Хувь хүнээс авах авлага	Ажиллагсадтай холбоотой	Байгууллагаас авах	Татаас санхүүжилтийн авлага	Зээлийн авлага
1	ЗДТГ	6,735.0	1,300.0	1,300.0	-	-	-	-
2	ЕБС	5,449.4	-	-	-	-	-	-
3	ЭМТ	185,722.9	-	-	-	-	-	-
4	Бага сургууль	14,040.0	-	-	-	-	-	-
5	СХС	69,439.5	45,255.3	-	-	-	-	45,255.3
6	ОНХС	3,828.0	2,940.0	2,940.0	-	-	-	-
	ДҮН	285,214.8	49,495.3	4,240.0	0	0	0	45,255.3
	Дүнд эзлэх хувь		100	8.6	0	0	0	91.4

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 380,270.2 мянган төгрөг байснаас тайлант онд 241,188.5 мянган төгрөгөөр буурч, оны эцэст бараа материалын үлдэгдэл 139,081.7 мянган төгрөг болсон байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	67,362.4	3,294.4	(64,068.0)
Эм боох материал	11,361.9	-	11,361.9
Дуусаагүй үйлдвэрлэл	65,936.3	48,975.8	(16,960.5)
Бичиг хэргийн материал	12,145.9	4,805.5	(7,340.4)
Аж ахуйн материал	190,289.9	37,307.0	(152,982.9)
Сэлбэг хэрэгсэл	1,800.0	-	1,800.0
Түлш, шатах тослох материал	2,208.6	-	2,208.6
Хүнсний материал	868.4	-	868.4
Бусад хангамжийн материал	23,286.8	40,739.0	17,452.2
Мал амьтад	5,010.0	3,960.0	(1,050.0)
Дүн	380,270.2	139,081.7	241,188.5

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 139,081.8 мянган төгрөг болж өмнөх оноос 241,188.5 мянган төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, хүүхдийн цэцэрлэг, соёлын төв нь улсын төсвийн байгууллага болсонтой холбоотой тухайн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдэхгүй болсонтой холбоотой байна.

Хүснэгт 5. Байгууллагын бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	Сургууль	Бага сургууль	Цэцэрлэг	Соёл	ЭМТ	ОНХС	Дүн
Эхний үлдэгдэл	2,722.0	64,272.8	106,491.0	7,411.0	54,703.4	9,597.0	69,136.7	65,936.3	380,270.2
Нэмэгдсэн	12,467.8	76,253.4	-	-	-	-	-	48,975.8	137,697.0
Худалдан авсан	12,467.8	54,253.4	-	-	-	-	-	48,975.8	115,697.0

**Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Шилжүүлэн авсан		22,000.0							22,000.0
Хандиваар ирсэн									
Бусад									
Хасагдсан	11,832.4	53,777.7	106,490.9	7,411.0	54,703.3	9,597.0	69,136.7	65,936.3	378,885.5
Худалдсан, зарцуулсан	11,932.4	53,777.7							65,610.0
Шилжүүлсэн								65,936.3	65,936.3
Бүтцийн өөрчлөлтөөр			106,491.0	7,411.0	54,703.4	9,597.0	69,136.7		247,338.9
Эцсийн үлдэгдэл	3,357.4	86,748.5	-	-	-	-	-	48,975.8	139,081.7

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 137,697.0 мянган төгрөгийн бараа материалын 115,697.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, ОНХС-аас 22,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна. Мөн нийт хасагдсан 378,885.5 мянган төгрөгийн 247,338.9 мянган төгрөг буюу 65.3 хувь нь шилжүүлсэн бүтцийн өөрчлөлттэй холбоотой байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 16,322,949.9 мянга, эцсийн үлдэгдэл 6,494,824.8 мянган төгрөг болж, 9,828,125.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	14,036,881.5	5,336,115.4	(8,700,766.1)
Тээврийн хэрэгсэл	339,411.8	247,927.8	(91,484.0)
Машин тоног төхөөрөмж	955,240.2	348,448.6	(606,791.6)
Тавилга эд хогшил	466,358.4	157,634.6	(308,723.8)
Зам гүүр	32,752.8	32,752.8	0
Номын фонд	43,465.7	-	(43,465.7)
Бусад үндсэн хөрөнгө	266,258.8	265,758.8	(500.0)
Программ хангамж	3,634.0	2,704.1	(929.9)
Бусад биет бус хөрөнгө	178,946.7	103,482.7	(75,464.0)
Дүн	16,322,949.9	6,494,824.8	(9,828,125.1)

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 7,531.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 1,443,372.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллагуудаас шилжүүлэн авч, өмнөх онд авлагаар бүртгэсэн байсан 6,735.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн байна..

Тайлант онд Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, соёлын төвийн байгууллагууд улсын төсвийн байгууллага болсонтой холбоотой бүтцийн өөрчлөлтөөр 11,222,110.5 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Хүснэгт 7. Байгууллагын үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	Сургууль	Бага сургууль	Цэцэрлэг	Соёл	ЭМТ	Дүн
Эхний үлдэгдэл	17,556.3	5,083,283.1	5,595,957.7	181,653.9	1,383,548.3	2,041,121.3	2,019,829.4	16,322,950.0
Нэмэгдсэн		1,443,372.9						1,443,372.9
Худалдан авсан		7,531.5						7,531.5
Шилжүүлэн авсан		1,429,106.4						1,429,106.4
Бусад	-	6,735.0	-	-	-	-	-	6,735.0
Хасагдсан	137.5	49,250.0	5,595,957.7	181,653.9	1,383,548.3	2,041,121.3	2,019,829.4	
Акталсан	-	45,850.0	-	-	-	-	-	45,850.0
Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	-	-	5,595,957.7	181,653.9	1,383,548.3	2,041,121.3	2,019,829.4	11,222,110.5
Шилжүүлсэн	-	2,400.0	-	-	-	-	-	2,400.0
Бусад	137.5	1,000.0	-	-	-	-	-	1,137.5
Эцсийн үлдэгдэл	17,418.8	6,477,406.0	-	-	-	-	-	6,494,824.8

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрт урт хугацаат зээл байхгүй, богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 12,378.9 мянган төгрөг байсныг тайлант онд бүрэн барагдуулсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:		
				Ажиллагсадтай холбоотой	Байгууллагад төлөх өглөг	Бараа үйлчилгээний зардлын өглөг
1	ЕБС	460.7	0.0	0.0	0.0	0.0
2	Цэцэрлэг	22.8	0.0	0.0	0.0	0.0
3	ЭМТ	11,885.4	0.0	0.0	0.0	0.0
4	Бага сургууль	10.0	0.0	0.0	0.0	0.0
	дүн	12,378.9	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 13,913,119.9 мянга, эцсийн үлдэгдэл 5,149,735.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 8,763,384.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	1,688,524.8	513,185.8	(1,175,339.0)	10.0
Хуримтлагдсан үр дүн	11,147,402.9	4,558,745.8	(6,588,657.1)	88.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,077,192.2	77,804.2	(999,388)	1.5
Дүн	13,913,119.9	5,149,735.8	(8,763,384.1)	100

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 8,763,384.1 мянган төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, соёлын төвийн байгууллагууд бүтцийн өөрчлөлтөөр тухайн тайлант нэгтгэгдээгүйтэй холбоотой байна.

3.5.10 Орлогын данс

Баянлиг сумын ИТХ-ын 2022.06.09-ний өдрийн хуралдааны 8/08 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 413,810.0 мянга, татварын бус орлогыг 5,000.0 мянга, нийт 418,810.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 10. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төвлөлгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	413,810.0	431,573.5	17,763.5	104.3
ЦХТА орлого /суутган/	217,000.0	228,396.2	11,396.2	105.3
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	3,000.0	2,381.6	(618.4)	79.4
Газрын төлбөр	3,400.0	3,218.9	(181.1)	94.7
ИОТХ	25,000.0	31,806.3	6,806.3	127.2
Галт зэвсгийн албан татвар	1,410.0	1,740.0	330.0	123.4
Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	2,963.8	963.8	148.2
Хадгаламжийн хүүгийн орлого	77,000.0	50,065.6	(26,934.4)	65.0
Малын тоо толгойн албан татвар	65,000.0	97,286.8	32,286.8	149.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	15,000.0	12,176.1	(2,823.9)	81.2

Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	4,000.0	800.0	(3,200.0)	20.0
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	1,000.0	250.0	(750.0)	25.0
Бусад татвар	0	488.3	488.3	
2.Татварын бус орлого	5,000.0	2,490.0	(2,510.0)	49.8
2.1.Хүү торгуулийн орлого	5,000.0	2,490.0	(2,510.0)	49.8
Нийт дүн	418,810.0	434,063.5	15,253.5	103.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 103.6 хувь буюу 15,253.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 11,396.2 мянга, иргэний орлого тодорхойлох хуудсаар 6,806.3 мянга, галт зэвсгийн албан татвар 330.0 мянга, улсын тэмдэгтийн хураамж 963.8 мянга, малын тоо толгойн албан татвар 32,286.8 мянга, бусад татвар 488.3 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин үл хөдлөх хөрөнгийн албан татвар 618.4 мянга, газрын төлбөр 181.1 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 26,934.4 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2,823.9 мянга, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 3,200.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 750.0 мянга, хүү торгуулийн орлого 2,510.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь иргэдийн хадгаламжийн хүү буурсан, ГХБХБГ-тай тусгай хамгаалалттай газар нутгийн гэрээг сүүлд хийсэн зэрэг шалтгаанаар орлого тасарсан байна.

Сумын ИТХ-ын 2022.06.09-ний өдрийн хуралдааны 8/08 дугаар тогтоолоор сумын ЗДТГ-ын өөрийн орлогыг 4,200.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн гүйцэтгэлээр уурын зуухны түрээсийн төлбөрийн 4,200.0 мянган төгрөгийн орлогыг оруулжээ.

Дээрх тогтоолоор сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн орлогоор тайлант онд 22,341.0 мянган төгрөгийг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 24,548.1 мянган төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 109.9 хувиар биелүүлсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн харилцах дансанд 210,676.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 45,255.3 мянган төгрөгийн авлагатай байна.

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,942,908.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,417,568.5 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,046,433.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 371,135.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

Хүснэгт 11. Төсвийн гүйцэтгэлийн тайлан хөтөлбөрөөр

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Баянлиг сумын Засаг дарга	1,942,908.8	1,416,431.0	526,477.8	72.9
2	70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	109,671.4	102,102.1	7,569.3	93.1
3	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	96,811.2	90,454.7	6,356.5	93.4
4	80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөх	5,443.8	5,443.8	-	100.0
5	80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал	6,286.3	5,738.1	548.2	91.3
6	82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	1,000.0	465.5	534.5	0.0
7	82310 Гамшгаас хамгаалах сургалт	130.1	-	130.1	
8	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	440,317.9	432,451.9	7,866.0	98.2
9	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	312,611.1	308,176.6	4,434.5	98.6
10	80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	68,984.0	67,165.9	1,818.1	97.4

11	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,200.0	1,200.0	-	100.0
12	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	23,767.0	22,710.3	1,056.8	95.6
13	80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	17,804.3	17,801.2	3.1	100.0
14	82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах	15,000.0	15,000.0	-	100.0
15	82310 Гамшгаас сэргийлэх	951.5	398.0	553.5	41.8
16	70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	635,769.0	371,135.3	264,633.7	58.4
17	80904 Нийгмийн зориулалттай барилга	177,437.6	161,487.3	15,950.3	91.0
18	83401 Итгэлцүүрээр олгох	293,462.0	199,207.6	94,254.4	67.9
19	83403 Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	40,423.8	-	40,423.8	0.0
20	83405 Малын тоо толгойн албан татвар	65,000.0	10,440.5	54,559.5	16.1
21	83406 Бусад	59,445.6	-	59,445.6	0.0
22	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	71,124.7	69,611.7	1,513.0	97.9
23	80112 ТШЗ-ийн байгууллагын тогтмол зардал	71,124.7	69,611.7	1,513.0	97.9
24	71702 Соёл урлаг	69,764.5	67,684.6	2,079.9	97.0
25	80112 ТШЗ-ийн байгууллагын тогтмол зардал	69,764.5	67,684.6	2,079.9	97.0
26	71801 Сургуулийн өмнөх боловсрол	57,420.0	54,476.9	2,943.1	94.9
28	80112 ТШЗ-ийн байгууллагын тогтмол зардал	57,420.0	54,476.9	2,943.1	94.9
29	71802 Ерөнхий боловсрол	323,829.7	304,473.8	19,355.9	94.0
30	80112 ТШЗ-ийн байгууллагын тогтмол зардал	323,829.7	304,473.8	19,355.9	94.0
31	71802 Бага сургууль	26,542.6	14,394.6	12,148.0	54.2
32	80112 ТШЗ-ийн байгууллагын тогтмол зардал	26,542.6	14,394.6	12,148.0	54.2
33	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	208,469.0	100.0	208,369.0	0.0
34	82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	208,469.0	100.0	208,369.0	0.0

Эх сурвалж: "Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн гүйцэтгэлийн тайлан"

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 4 төсвийн байгууллага, улсын төсвийн 2 сургууль, цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төвийн тогтмол зардлын төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Баянлиг сумын ИТХ-ын 2021.12.15-ны өдрийн хуралдааны 6/05 дугаар тогтоолоор нийт 1,888,963.7 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт 12. Байгууллагуудын төсвийн төсөл, батлагдсан төсөв /мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	96,279.7	77,148.8	
Засаг даргын Тамгын газар	579,307.8	381,446.2	
Сургууль	238,145.42	355,081.4	
Бага сургууль	9,360.0	46,345.6	

Цэцэрлэг	48,471.6	75,675.9
Эрүүл мэндийн төв	85,259.8	71,124.7
Соёлын төв	88,444.0	67,532.0
Сум хөгжүүлэх сан		195,482.4
Орон нутгийн хөгжлийн сан		619,126.7
Нийт дүн	1,145,268.32	1,888,963.7

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудас, сумын ИТХХ-ын тогтоол

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2021.12.15-ны өдрийн хуралдааны 6/05 дугаар тогтоолоор анх баталсан 1,888,963.7 мянган төгрөгийг сумын ИТХ-ын хуралдааны 2022.03.21-ны өдрийн 7/16 дугаар тогтоолоор төсвийг 91,889.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,980,853.3 мянган төгрөгийн төсөв баталсан. ИТХ, ЕБС, Бага сургууль, Цэцэрлэг, Соёлын төв, ОНХС-ийн төсвийг аймгийн ИТХ-ын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 9/24 дугаар тогтоолоор 102,144.5 мянган төгрөгөөр бууруулснаас сумын төсөв ИТХ-ын хурлын 2022.06.09-ны өдрийн 8/08 дугаар тогтоолоор 1,942,908.8 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 418,810.0 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 393,331.4 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 668,984.9 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 26,541.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 73,559.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 176,554.0 мянган төгрөгийг ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс, 186,128.0 мянган төгрөгийг СХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, ОНХС-ийн шилжүүлгийг 2,163.3 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авч, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг 2,207.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, оны эцэст зардлын хэмнэлтээс 53,475.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 13. Байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН-ын төсөвт төвлөрүүлсэн	Улсын төсөвт төвлөрүүлсэн
Засаг даргын Тамгын газар	440,317.90	432,451.9	7,866.0	98.2	7,866.0	0.0
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	109,671.40	102,102.0	7,569.3	93.1	7,569.3	0.0
Ерөнхий боловсролын сургууль	323,829.70	304,473.8	19,355.9	94.0	19,355.9	0.0
Бага сургууль	26,542.60	14,394.6	12,148.0	54.2	12,148.0	0.0
Цэцэрлэг	57,420.00	54,476.9	2,943.1	94.9	2,943.1	0.0
Эрүүл мэндийн төв	71,124.70	69,611.7	1,513.0	97.9	1,513.0	0.0
Соёлын төв	69,764.50	67,684.6	2,079.9	97.0	2,079.9	0.0
Орон нутгийн хөгжлийн сан	635,769.00	371,135.3	264,633.7	58.4	0	0.0
Сум хөгжүүлэх сан	208,469.00	100.0	208,369	0.0	0	0.0
Нийт дүн	1,942,908.80	1,416,430.9	526,477.8	72.9	53,475.2	0.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Жинст сумын байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,416,430.9 мянган төгрөг буюу 72.9 хувьтай байгаа нь Сум хөгжүүлэх сангаас 208,469.0 мянган төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн ч олгоогүй, он дамжсан юнителийн сүлжээний ажлын 107,000.0 мянга, 3 удаа тендер зарласан боловч оролцогч оролцоогүй жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих ажлын байрыг засварлах ажлын 25,000.0 мянга, 1 дүгээр багт худаг гаргах ажлын 28,000.0 мянга, зураг төсвийн 20,000.0 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ хийгдээгүйгээс он дамжсан байна.

Мөн ТШЗ-ийн байгууллагын тогтмол зардал, ИТХ, ЗДТГ-ын хангамжийн материал, шатахуун, хуралдааны зардал хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 230,241.9 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт өгснөөс бараа үйлчилгээний зардалд 188,355.2 мянган төгрөг зарцуулж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад 13,337.5 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 24,838.8 мянган төгрөгийг зарцуулж оны 3,710.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 14. Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлага, төвлөрүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗДТГ	ИТХ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	12,917.3	1,300.0	14,217.3
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,656.3	1,300.0	9,956.3
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,261.0	0	4,261.0
НИЙТ ЗАРЛАГА	12,917.3	1,300.0	14,217.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	10,776.7	1,026.4	11,803.1
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,140.6	273.6	2,414.2

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Татварын байцаагч малын тоо толгойн албан татварыг 2022 онд 125,229.4 мянган төгрөгөөр ногдуулсан байхад сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 6/05 дугаар тогтоолоор малын хөлийн албан татварыг 40,000.0 мянган төгрөгөөр баталсан, тодотголоор 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны 8/08 дугаар тогтоолоор нэмэгдүүлэн 65,000.0 мянган төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр 97,414.8 төгрөгийн орлого төвлөрч 32,414.7 мянган төгрөгөөр төлөвлөгөө давж биелсэн нь төсвийн төлөвлөлтийг татварын ногдуулалттай уялдаагүй хийсэнтэй холбоотой байна.

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 85.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Тайлант онд хэрэгжүүлэх 5 үндсэн зорилт, 30 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 1,942,908.8 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,417,568.5 мянган төгрөгийг зарцуулж, 73.0 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус сум нь 13 нэр төрлийн орлогоор 418,810.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 434,063.5 төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 103.6 хувь буюу 15,253.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь малын тоо толгойн албан татвар 32,286.7 мянган төгрөг орсонтой холбоотой байна. Орлогын нэр төрлөөр нь авч үзвэл 7 нэр төрлийн орлого 37,017.8 мянган төгрөгөөр тасарсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 5 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Баянлиг сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна. Хүснэгт №15. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо					Аудитын санал дүгнэлтийн төрөл					
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн			Бүгд	Үүнээс				
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан			Зөрчилг үй	Хязгаар лалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
ЗДТГ	1	1			1						
ИТХурал	1	1			1						
ОНХС	1	1			1						
СХС	1	1			1						
НИЙТ ДҮН	4	4			4	0	0	0			0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 33,014.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,940.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 960.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 30,064.4 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №16. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн зөрчил										
ИТХурал	1	1,100.0							1	1,100.0
ЗДТГ	3	4,392.7			2	960.0			1	4,383.1
ОНХСан	1	2,940.0					1	2,940.0		
СХС	1	24,581.3							1	24,581.3
СТА зөрчлийн дүн	6	33,014.0	0	0	2	960.0	1	2,940.0	3	30,064.4
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ИТХурал	1	-								-
Нийцлийн аудитын дүн	1	-	-	-	-	-	-	-	1	-
Нийт дүн	7	33,014.0	0	0	2	960.0	1	2,940.0	4	30,064.4

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлөөс санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 33,014.0 мянган төгрөгийн 6 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 1 зөрчил тус тус илэрсэн байна.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн

/мянган төгрөгөөр/

Огноо	Аудитын нэр:	Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:
2022			БНА-2023/14/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянлиг сумын Засаг дарга	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
Харьяа төсвийн байгууллагуудын дүн		33,014.0			

**Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
Засаг даргын тамгын газар		5,343.1			
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл					
1	Баянхонгор аймгийн түүхт 80, 81 жилийн ойд Засаг даргын нөөц хөрөнгөөс 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдөр шатахуун, айраг, иргэний ундаа, махны үнэнд нийт 4.383.050 төгрөгийг зарцуулсан байна.	4,383.1	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Г.Мөнхсүх, С.Мөнхцэцэг
2	Засаг даргын нөөц хөрөнгөөс 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр эко аяллын бэлэг дурсгалд 360,000 төгрөг, 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр ногоочид саальчдын өдөрлөгт зориулсан бэлэг дурсгалд 200,000 төгрөгийг зарцуулсан байна.	560.0	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Г.Мөнхсүх, С.Мөнхцэцэг
3	Худалдан авах ажиллагааны АЗ сургалтын төлбөрт 2022.12.28-ны өдөр 4 албан хаагчид тус бүр 100.0 мянга, нийт 400,000 төгрөгийг зарцуулсан байна.	400.0	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Г.Мөнхсүх, С.Мөнхцэцэг
Дүн					
Иргэдийн төлөөлөгчдийн хурал		1,100.0			
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл					
1	Байгууллагын тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 1100.0 мянган төгрөгийн үнэтэй мотоциклийг нүд үзэн тоолоход ашиглаг боломжгүй болсон. Аймгийн ОНӨГ-т актлах саналыг хүргүүлсэн.	1,100.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Э.Мөнхсарнай, Б.Адъяасүрэн
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал					
2	Шилэн дансны тухай хуулиар 128 мэдээлэл байршуулахаас 5.7 сая төгрөгийн 8 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Э.Мөнхсарнай, Б.Адъяасүрэн
Орон нутгийн хөгжлийн сан		2,940.0			
1	Ногоон байгууламж нэмэгдүүлэх, мод тарих услалтын систем сайжруулах ажлын урьдчилгаанд 8.940.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон боловч ажил хийгдээгүй, урьдчилгаа санхүүжилтээс 6,000.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж 2,940.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4 дэх "Сум, дүүргийн Засаг даргын чиг үүрэг", 3.4.3 дахь "Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих", 11.1 дэх "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна" гэсэн заалтыг зөрчсөн байна.	2,940.0	Албан шаардлага	Засаг дарга, Нягтлан бодогч	О.Мөнхбат, С.Мөнхцэцэг
Сум хөгжүүлэх сан		24,581.3			
1	СХС-аас 2013-2014 онд олгосон 2 иргэний 24,581,344 төгрөгийн зээл хугацаа хэтэрснийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлсэн боловч 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 2/84, 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 120 дугаар албан бичгүүдээр буцаан татсан бөгөөд уг зээлийг барагдуулаагүй байна.	24,581.3	Зөвлөмж	Засаг дарга, Нягтлан бодогч	О.Мөнхбат, С.Мөнхцэцэг

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Баянлиг сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Засаг даргын нөөц хөрөнгөөс 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр эко аяллын бэлэг дурсгалд 360,000 төгрөг, 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр ногоочид саальчдын өдөрлөгт зориулсан бэлэг дурсгалд 200,000 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар

зүйлийн 15.1.5. дахь "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд дээрх зөрчилд ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоосон.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Төрийн хэмнэлтийн хуулийг сумын ЗДТГ нь хэрэгжүүлж ажиллаагүй гэж үзлээ.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 153 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг мэдээллийн хугацаа болоогүй байна.

Хүснэгт 18. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	12	12	10	-	2
2	Хагас жил	3	3	3	-	-
3	Улирал бүр	2	8	8	-	-
4	Сар бүр	5	60	60	-	-
5	Тухай бүр	6	72	72	-	-
	Нийт	28	155	153	-	2

Эх сурвалж. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийсэн ба жилийн эцсээр дүнг нэгтгэн танилцуулсан болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 9,261.3 мянган төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 130 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 19. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж

/ мянган төгрөгөөр /

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	5	9,261.3	5	9,261.3	-	-	100
Нийт	5	9,261.3	5	9,261.3	-	-	100

Эх сурвалж: Шийдвэрийн хэрэгжилт

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил давтан гаргахгүй байх 35,388.0 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж, сахилгын арга хүргүүлээ.

5.1. Албан шаардлага

1. Баянлиг сумын Сум хөгжүүлэх сангаас 2013 онд зээл авсан Ц.Бийбатын 10,304,334 төгрөг, 2014 онд зээл авсан А.Цогтгэрэлийн 14,277,010 төгрөг нийт 24,581,344 төгрөгийн зээл хугацаа хэтэрснийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн байхад сумын Засаг дарга А.Бадмаадорж 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 2/84, О.Мөнхбат 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 120 дугаар албан бичгээр зээлийг 2021 оны 1, 10 дугаар саруудад буцааж төлж дуусгана гэсэн хүсэлт хүргүүлж, зээлийг татсан байна.

Дээрх зээлдэгч нар 2022 оны жилийн эцсийн байдлаар авсан зээлийг барагдуулаагүй, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг сумын Засаг дарга хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 103.6 хувь буюу 15.253.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч үл хөдлөх хөрөнгийн албан татвар 618.4 мянга, газрын төлбөр 181.1 мянга, хог хаягдлын хураамж 2,823.9 мянга, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 3,200.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 750.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Өгсөн зөвлөмж: Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах.

2. Татварын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Татварын байцаагч малын тоо толгойн албан татварыг 2022 онд 125,229.4 мянган төгрөгөөр ногдуулсан байхад Сумын ИТХ-ын 2022.06.09-ний өдрийн хуралдааны 8/08 дугаар тогтоолоор 65,000.0 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 97,414,750 төгрөгийн биелэлттэй байна.

Өгсөн зөвлөмж: Малын тоо толгойн албан татварыг хуулийн дагуу ногдуулалтай уялдуулан төлөвлөх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3. Сум хөгжүүлэх сангийн зээл олголттой холбоотой.

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангаас тайлант онд 200,000.0 мянган төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн ч тайлант онд зээл олгоогүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийг олгож, сангийн үр ашгийн нэмэгдүүлэх.

4. Дотоод, хяналт хариуцлагатай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 33,014.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,940.0 мянган

төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 960.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 30,064.4 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид сумын Засаг дарга Төсвийн тухай хуулийг мөрдөж Засаг дарга өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад тавих хяналт, төсвийн хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо 2022	Аудитын нэр:	Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код: БНА-2021/14/СТА-ТТЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянлиг сумын Засаг дарга	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
	ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар:				
1	Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 103.6 хувь буюу 15,253.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч үл хөдлөх хөрөнгийн албан татвар 618.4 мянга, газрын төлбөр 181.1 мянга, хог хаягдлын хураамж 2,823.9 мянга, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 3,200.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 750.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.	7,573.4	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга	О.Мөнхбат, Ш.Хоролсүрэн
2	Татварын байцаагч малын тоо толгойн албан татварыг 2022 онд 125,229.4 мянган төгрөгөөр ногдуулсан байхад Сумын ИТХ-ын 2022.06.09-ний өдрийн хуралдааны 8/08 дугаар тогтоолоор 65,000.0 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 97,414.8 мянган төгрөгийн биелэлттэй, татварын ногдуулалтаас 27,814.6 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.	27,814.6	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга	О.Мөнхбат, Ш.Хоролсүрэн
3	Хоршоо хөгжүүлэх сангаас тайлант онд 200,000.0 мянган төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн ч тайлант онд зээл олгоогүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга	О.Мөнхбат, Ш.Хоролсүрэн
4	Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 33,014.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,940.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 960.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 30,064.4 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга	О.Мөнхбат, Ш.Хоролсүрэн
5	Баянлиг сумын Сум хөгжүүлэх сангаас 2013 онд зээл авсан Ц.Бийбатын 10,304,334 төгрөг, 2014 онд зээл авсан А.Цогтгэрэлийн 14,277,010 төгрөг нийт 24,581,344 төгрөгийн зээл хугацаа хэтэрснийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн байхад сумын Засаг дарга А.Бадмаадорж 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 2/84, О.Мөнхбат 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 120 дугаар албан бичгээр зээлийг 2021 оны 1, 10 дугаар саруудад буцааж төлж дуусгана гэсэн хүсэлт хүргүүлж, зээлийг татсан байна. Дээрх зээлдэгч нар 2022 оны жилийн эцсийн байдлаар авсан зээлийг барагдуулаагүй, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг сумын Засаг дарга хэрэгжүүлээгүй байна.	-	Хариуцлага тооцуулах албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга	О.Мөнхбат, Ш.Хоролсүрэн
	ДҮН	35,388.0			

---oOo---